210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,145,500.00	1,125,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,398,900.00	37,886,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,879,400.00	2,869,900.00
210604	Урсгал засвар	35,519,500.00	35,016,500.00
2107	Томилот, зочны зардал	12,287,300.00	12,278,000.00
210702	Дотоод албан томилот	12,287,300.00	12,278,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,237,700.00	6,193,277.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,986,300.00	4,979,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	180,000.00	174,705.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	193,072.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	80,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	408,200.00	407,500.00
210807	Газрын төлбөр	133,200.00	133,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,019,700.00	36,991,250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,033,800.00	31,006,750.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,985,900.00	5,984,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,034,200.00	36,000,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,034,200.00	36,000,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	33,474,600.00	33,474,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,559,600.00	2,526,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	433,976,600.00	265,305,348.00
223001	Бусад хөрөнгө	433,976,600.00	265,305,348.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	147,650,000.00	94,000,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	147,650,000.00	94,000,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,959,620,300.00	1,738,319,943.05
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	215,830,200.00	215,830,200.00
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	215,830,200.00	215,830,200.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,533,182,300.00	1,450,578,585.05
320001	Орон нутгийн төсвөөс	1,533,182,300.00	1,450,578,585.05
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	210,607,800.00	71,911,158.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,000,000.00	71,911,158.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	60,607,800.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	129,684,722.79
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	149,320,454.30
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	214.00	164.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00
610001	Төсвийн байгууллага	2.00	2.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	106.00	81.00
620001	Удирдах ажилтан	14.00	14.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00
620004	Гэрээт ажилтан	79.00	54.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	106.00	81.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11.00	11.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	79.00	56.00
650010	Гэрээт ажилтан	3.00	1.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	13.00	13.00

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,928,921.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,928,921.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,928,921.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,360,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,360,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,219,000.00
210604	Урсгал засвар	1,219,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,349,921.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,049,921.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,928,921.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,928,921.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,689,921.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,239,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 192.6 сая төгрөг болж, өмнөх оноос 32.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	/сая төгрөг/ Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах	225.5	192.6	-32.9	14.6
Дүн	225.5	192.6	-32.9	14.6

Эх сурвалж: Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 192.6 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 354.6 сая, эцсийн үлдэгдэл 276.1 сая төгрөг болж, 78.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төлбөртэй үйлчилгээний авлага	91.5	0.0	-91.5
Ажиллагсадтай холбоотой авлага	1.3	0.5	-0.9
Байгууллагаас авах авлага	14.0	0.0	-14.0
Хувь хүмүүсээс авах авлага	0.0	0.0	0.0
Зээлийн авлага	247.8	275.6	27.8
Дүн	354.6	276.1	-78.5

Эх сурвалж: Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэл 127.5 сая төгрөг болж 152.4 сая төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн төв, Цэцэрлэгийн авлага буурснаас шалтгаалжээ.

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 446.6 сая, эцсийн үлдэгдэл 109.7 сая төгрөг болж, 336.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Эм боох материал	48.2	0.0	-48.2
Бичиг хэргийн материал	11.6	1.2	-10.4
Аж ахуйн материал	171.7	11.4	-160.3

Сэлбэг хэрэгсэл	0.5	0.3	-0.2
Түлш шатах тослох материал	29.6	1.4	-28.2
Барилгын засварын материал	1.0	0.4	-0.6
Хүнсний материал	35.6	0.0	-35.6
Бусад хангамжийн материал	136.6	55.1	-81.5
Мал амьтад	12.0	40.0	28.0
Дүн	446.6	109.7	-336.9

Эх сурвалж: Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 109.7 сая төгрөг болж 336.9 сая төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын бараа материалыг улсын төсвийн дансанд шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 13,478.7 сая, эцсийн үлдэгдэл 3,660.6 сая төгрөг болж, 9,818.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	13,349.2	3,603.2	-9,746.0
Хуримтлагдсан элэгдэл	-1,259.8	-561.1	698.7
Авто тээврийн хэрэгсэл	485.9	336.2	-149.6
Хуримтлагдсан элэгдэл	-267.3	-91.9	175.3
Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,328.9	365.4	-963.5
Хуримтлагдсан элэгдэл	-868.2	-189.5	678.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	461.3	57.0	-404.3
Хуримтлагдсан элэгдэл	-267.3	-43.8	223.5
Зам гүүрний барилга байгууламж	50.0	50.0	0.0
Хуримтлагдсан элэгдэл	-50.0	-50.0	0.0
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	0.0	0.0	0.0
Бусад үндсэн хөрөнгө	163.9	6.3	-157.6
Хуримтлагдсан элэгдэл	-57.6	-5.3	52.3
Ном	173.2	119.0	-54.2
Программ хангамж	2.5	1.5	-1.0
Хуримтлагдсан элэгдэл	-2.5	-1.5	1.0
Бусад биет бус хөрөнгө	236.9	64.9	-172.0
Хуримтлагдсан элэгдэл	-0.4	0.0	0.4
Дүн	13,478.7	3,660.6	-9,818.2

Эх сурвалж: Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,660.6 сая төгрөг болж 9,818.2 сая төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын үндсэн хөрөнгийг улсын төсвийн дансанд шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 17.6 сая, эцсийн үлдэгдэл 1.7 сая төгрөг болж, 15.9 төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	/сая төгрөг/ Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбоотой өглөг	8.8	1.2	-7.6	85.9
Байгууллагад төлөх өглөг	8.5	0.5	-8.0	94.7
Хувь хүмүүст төлөх өглөг	0.3	0.0	-0.3	100.0
Нийт дүн	17.6	1.7	-15.9	90.4

Эх сурвалж: Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл 1.7 сая төгрөг болж 15.9 төгрөгөөр буурсан нь хувь хүмүүст төлөх болон ажилчидтай холбоотой өглөг буурснаас шалтгаалжээ. Өглөг дансанд байгууллагад төлөх 0.5 сая, ажилчидтай холбоотой 1.2 сая төгрөгийн өглөг байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 14,487.8 сая, эцсийн үлдэгдэл 4,237.2 сая төгрөг болж, 10,250.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/	
			Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал				
/Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,326.2	485.4	-1,840.8	79.1
Хуримтлагдсан үр дүн	7,341.7	2,923.6	-4,418.1	60.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,4819.9	828.3	-3,991.7	82.8
Дүн	14,487.8	4,237.2	-10,250.6	70.8

Эх сурвалж: Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4,237.2 сая төгрөг болж 10,250.6 сая төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан үр дүнгээс шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүн 2,923.6 сая төгрөг болж 4,418.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Тайлант онд Тэс суманд татварын орлого 276.3 сая, татварын бус орлого 409.5 сая, тусламж санхүүжилтийн орлого 2807.8 сая, нийт 3,493.6 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон байна.

3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой Төсвийн шууд захирагчид 175.7 сая төгрөгийн 3 зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:

Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь шилэн дансны цахим хуудаст 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 8.5 сая төгрөгийн 5 мэдээлэл, 4.5 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах 7 шийдвэрийг байршуулаагүй зөрчилд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага өглөө.

Тэс сумын Засаг даргын тамгын газар:

- Тэс сумын Засаг даргын тамгын газар нь шилэн дансны цахим хуудаст 148.2 сая төгрөгийн 9 мэдээлэл, 14.1 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах 49 шийдвэрийг байршуулаагүй зөрчилд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага өглөө.

- Тэс сумын Засаг даргын тамгын газар нь анхан шатны баримтын бүрдэлгүй 14.5 сая төгрөгийн 26 гүйлгээ хийсэн зөрчилд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэж, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтад "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгсөн.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,533.2 сая, урьд оны үлдэгдлээс санхүүжих 60.6 сая, ОНХС-ийн шилжүүлгээр 215.8 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 150.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тэс сумын 2022 оны төсвийг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 5/03 дугаар тогтоолоор 2,269.4 сая төгрөгөөр баталж 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 7/05 дугаар тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 309.8 сая төгрөгөөр бууруулж 1,959.6 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,959.6 сая төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 1,533.2 сая, урьд оны үлдэгдлээс санхүүжих 60.6 сая, ОНХС-ийн шилжүүлгээр 215.8 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 150.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,450.6 сая, ОНХС-ийн шилжүүлгээр 215.8 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 71.9 сая төгрөгийг санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,693.1 сая төгрөгийг зарцуулж, 38.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,693.1 сая төгрөг буюу 86 хувьтай байгаа нь зардлыг 38.4 сая төгрөгөөр хэмнэж, гүйцэтгэлээр Орон нутгийн татварын орлого 39.9 сая төгрөгөөр дутуу биелж, 192.6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарснаас шалтгаалжээ.

Тэс сумын ИТХ-ын 2022 оны тодотгосон төсөв батлах тухай 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 7/05 дугаар тогтоолоор Тэс сумын Засаг дарга тайлант онд 316.2 сая төгрөгийн татварын орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 276.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 87.4 хувиар биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 3.7 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3.7 сая, нийт 7.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 6.9 сая төгрөгийг зарцуулж 0.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 29.8 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөхгүйгээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн

нийт зардал 2,984.3 сая төгрөгийн 0.5 хувь буюу 14.9 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 11.9 сая төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/697 дугаар захирамжийн дагуу сумын орон нутгийн орлогоос 40.0 сая төгрөгийг аймгийн орон нутгийн орлогод татаж авснаас шалтгаалж татварын орлогын 39.9 сая төгрөгөөр тасарсан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллээс хугацаандаа оруулсан 78, хугацаа хоцроож 65 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан ба 289.3 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах 18 шийдвэрийг байршуулаагүй, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь шилэн дансны цахим хуудаст 65 мэдээллийг хугацаа хоцроосон, 289.3 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах 18 шийдвэрийг байршуулаагүй зөрчилд зөвлөмж өглөө.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4.7 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 10 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 12 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 санг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 10 байгууллагаас 9 санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 1 байгууллагад “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 189.8 сая төгрөгийн 3 зөрчил илрүүлж 2 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ИТХ	1	13.0					1	13.0		
2	ЗДТГ	1	162.3					1	162.3		
		1	14.5							1	14.5
Дүн		3	189.8					2	175.3	1	14.5

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 289.3 сая төгрөгийн 1 зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь шилэн дансны цахим хуудаст 65 мэдээллийг хугацаа хоцроосон, 289.3 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах 18 шийдвэрийг байршуулаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тэс сумын ТТЗ	1	289.3					1	289.3
Дүн	1	289.3					1	289.3
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	289.3					1	289.3

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /ИМ. БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/ИМ. БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

/Б.АВИРМЭД/

2023 оны 03 сарын 20-ны өдөр